

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ АУДИТ

АУДИТЫН КОД: СЭА-2025/03-17-НА-НА

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ 318.9 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ, УРСГАЛ ЗАРДЛЫГ 129.8 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ, ТӨСВИЙН ҮР АШГИЙГ 4,201.2 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА.

Сүхбаатар сум 2025 он

**Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч Б.Батмөнх**

Утас: 70363040 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Отгонбаяр

Утас: 70363047 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn

Аудитор О.Анхбаяр

Утас: 70363047 Цахим хаяг: Ankhbayar0@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас:
www.open.audit.mn

АГУУЛГА	
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгт, зургийн товьёг	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	4
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
БҮЛЭГ 1. АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ХУУЛЬ, ЭРХИЙН АКТАД НИЙЦСЭН БАЙНА.	6
1.1. Аймгийн 2026 оны төсвийн төслийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй нийцүүлэн боловсруулсан байна.	6
1.2. Аймгийн 2026 оны төсвийн төслийг хуульд заасан хугацаанд иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.	6
БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ БОРЛУУЛСНЫ ОРЛОГЫГ ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР НЭМЭГДҮҮЛЭН ТООЦСОН БАЙНА.	7
2.1. Эрх бүхий албан тушаалтны ногдуулсан торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэх замаар 318.9 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэх нөөц боломж байна.	7
2.2. Татварын өрийг хуульд заасан хувь хэмжээгээр барагдуулж орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг тооцсон байна.	9
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БҮТЭЦ ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АКТАД НИЙЦҮҮЛЭН ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	9
3.1. Орон нутгийн нөөц боломжид үндэслэн суурь зардлыг 24,773.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.	9
3.2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж, комиссын актаар хүлээн авсан зарим төсөл арга хэмжээний ашиглалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.	10
БҮЛЭГ 4. АЙМГИЙН ОНХО, ОНХС, ЗАМЫН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР ЗУРАГ, ТӨСВИЙГ УРЬДЧИЛАН ХИЙЛГЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨСӨВЛӨСӨН БАЙНА.	12
4.1. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг ОНХО-ын төлөвлөгөөнд тусгасан байна.	12
4.2. Зураг төсвийг урьдчилан хийлгээгүй болон чиг үүрэгт хамаарахгүй төсөл арга хэмжээг ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	14
ДҮГНЭЛТ	16
ЗӨВЛӨМЖ	17
ХАВСРАЛТ	

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
БОГ	Байгаль орчны газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТСХ	Санхүү, Төрийн сангийн хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
УИХ	Улсын Их Хурал
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар

Хүснэгтийн товъёг:

Хүснэгт 1	Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо	8
Хүснэгт 2	Сумдын ЗДТГ-ын орон тооны судалгаа	11
Хүснэгт 3	Хөрөнгө ашиглалттай холбоотой судалгаа	12
Хүснэгт 4	Аймгийн ОНХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа	13
Хүснэгт 5	Зураг төсөв, тооцоо судалгаагүй төлөвлөсөн төсөл, арга хэмжээний судалгаа	13
Хүснэгт 6	Улсын төсвийн байгууллагуудыг санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт	14
Хүснэгт 7	Зураг төсөв, тооцоо судалгаагүйгээр Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний судалгаа	14
Хүснэгт 8	ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа	14

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 болон УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго:

Сэлэнгэ аймгийн 2026 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ-д хүргүүлэн, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэв.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- *Орон нутгийн төсвийн төслийг хууль, эрх зүйн актад нийцүүлэн төлөвлөсөн үү?*
- *Орон нутгийн төсвийн орлогын нөөц боломжийг бүрэн ашиглаж төлөвлөсөн үү?*
- *Орон нутгийн төсвийн зарлагыг арвилан хэмнэлт, үр ашигтай байхаар төлөвлөсөн үү?*
- *Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хууль эрхийн актад нийцүүлэн төлөвлөсөн үү?*

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж, ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг гол шалгуур болголоо.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг Сэлэнгэ аймгийн 2024, 2025 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл (батлагдсан болон урьдчилсан), аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн 2026

оны төсвийн төсөл, холбогдох танилцуулга мэдээлэл, төсвийн орлого бүрдүүлдэг зарим байгууллагаас ирүүлсэн судалгаа, мэдээллийг хамруулан гүйцэтгэв.

Талуудын хүлээх үүрэг, хариуцлага:

Аймгийн Засаг дарга Сэлэнгэ аймгийн 2026 оны төсвийг танилцуулгын хамт бэлтгэн, Төсвийн тухай хуулийн 8.5.1-д заасан цаглабарын дагуу Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн аймгийн 2026 оны төсвийн төслийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах үүрэг хүлээнэ.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батмөнх удирдан явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Ц.Отгонбаяр, С.Баасансүрэн, Т.Болор, аудитор О.Анхбаяр, Ж.Цогт, Б.Наранцэцэг нар 2025 оны 09 дүгээр сарын 20-оос 11 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

УИХ-аас аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 42,700.0 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 2,109.7 сая төгрөгөөр буюу аймгийн татварын болон татварын бус орлогыг **44,809.7 сая** төгрөгөөр, сумдын татварын болон татварын бус орлогыг 56,023.5 сая төгрөгөөр тооцон нийт **суурь орлогыг 100,833.2 сая** төгрөгөөр, **суурь зардлыг 66,372.9 сая** төгрөгөөр, үндсэн тэнцлийн ашгийн 30 хувь буюу **10,338.1 сая төгрөгийг улсад төвлөрүүлэх шилжүүлгээр** хянаж, баталсан байна.

ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг нийт **24,972.6 сая** төгрөгийг Сэлэнгэ аймагт хуваарилснаас 33.3 хувь буюу 8,305.8 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 66.7 хувь буюу 16,666.8 сая төгрөгийг сумдын ОНХС-д хуваарилсан байна.

УИХ-аас батлагдаж ирсэн аймгийн татварын болон татварын бус орлогыг нийт 947.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн **45,756.9 сая** төгрөгөөр, сумдаас аймагт төвлөрүүлэх орлогыг 5,265.3 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 24,972.6 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлийг 4,203.1 сая төгрөгөөр, улсад төвлөрүүлэх орлогыг 10,338.1 сая төгрөгөөр тооцон төсвийг санхүүжүүлэх эх үүсвэр болон зардлыг **69,859.8 сая** төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ХУУЛЬ, ЭРХИЙН АКТАД НИЙЦСЭН БАЙНА.

1.1 АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР БОЛОН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ НИЙЦҮҮЛЭН БОЛОВСРУУЛСАН БАЙНА.

1.1.1 Сэлэнгэ аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй нийцүүлэн боловсруулсан байх ёстой.

1.1.2 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1¹, 15.2²-д заасны дагуу аймгийн ИТХ нь Засаг даргын өргөн мэдүүлсэн “Сэлэнгэ аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг 2025 оны 12 дугаар сард багтаан батлахаар заасан байна.

1.1.2 Иймд аймгийн 2026 оны төсвийн төслийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн 2026 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй нийцүүлэн хууль, журамд заасан шаардлагын дагуу боловсруулсан эсэхийг тулган баталгаажууллаа.

1.1.3 Төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2026 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байна.

1.2 АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД ИЖ БҮРЭН БЭЛТГЭЖ ИРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

1.2.1 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх”-ээр заасан байна.

1.2.2 Гэтэл аймгийн Засаг дарга 2026 оны төсвийн төслийг 2025 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Төрийн аудитын байгууллагад хүргүүлсэн нь аудитыг хугацаанд нь хийж гүйцэтгэхэд хүндрэл учруулсан болно.

1.2.3 Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2026 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2³-т зааснаар хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг тодорхойлж ирүүлсэн байна.

¹ Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд суурилсан Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэл, хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал харуусан захиргааны байгууллагатай хамтран өмнөх төлөвлөгөөний баримт бичиг дуусгавар болохоос гурван сарын өмнө боловсруулна.

² Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг өмнөх баримт бичиг дуусгавар болохоос өмнө батална.

³ Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх;

1.2.4 Төсвийн төслийг хууль, журмын дагуу үндэслэлтэй боловсруулсан эсэхийг тулган баталгаажуулахад төсвийн төслийг иж бүрэн бэлтгээгүй, хавсралт, дагалдах тооцоо, судалгаа дэмжих баримт хангалтгүй байна.

БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ БОРЛУУЛСНЫ ОРЛОГЫГ ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР НЭМЭГДҮҮЛЭН ТООЦСОН БАЙНА.

2.1 ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗАМААР 318.9 САЯ ТӨГРӨГИЙН ОРЛОГЫГ ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ НӨӨЦ БОЛОМЖ БАЙНА.

2.1.1 УИХ-аас аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 42,700.0 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 2,109.7 сая төгрөгөөр буюу аймгийн татварын болон татварын бус орлогыг **44,809.7 сая** төгрөгөөр, сумдын татварын болон татварын бус орлогыг 56,023.5 сая төгрөгөөр тооцон нийт **суурь орлогыг 100,833.2 сая** төгрөгөөр батлан ирүүлсэн байна.

2.1.2 ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг нийт **24,972.6 сая** төгрөгийг Сэлэнгэ аймагт хуваарилагдсанаас 33.3 хувь буюу 8,305.8 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 66.7 хувь буюу 16,666.8 сая төгрөгийг сумдын ОНХС-д хуваарилсан байна.

2.1.3 УИХ-аас батлагдаж ирсэн аймгийн татварын болон татварын бус орлогыг нийт 5,150.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 49,960.0 сая төгрөгөөр, сумдаас аймагт төвлөрүүлэх орлогыг 5,265.3 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 24,972.6 сая төгрөгөөр, улсад төвлөрүүлэх орлогыг 10,338.1 сая төгрөгөөр тооцон төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийт 69,859.8 сая төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна. Нэмэгдүүлэн төсөвлөсөн төсвийн орлого, эх үүсвэрийг нэр төрлөөр нь харуулбал:

- *Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 150.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,150.0 сая төгрөгөөр,*
- *Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 0.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 60.0 сая төгрөгөөр,*
- *Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 5,150.0 сая төгрөгөөр,*
- *Сумдын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 5,265.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төсөвлөсөн байна.*

2.1.4 Аудитаар авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар болон өөрийн орлогыг нэмэгдүүлсэн тооцооллыг хянаж үндэслэлтэй гэж дүгнэлээ.

2.1.5 Харин хөрөнгө борлуулсны орлогыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь үндэслэлгүй байгаа тул дахин тооцоо судалгаа хийж, нэмэгдүүлэх боломжтой эх үүсвэрийг боломжтой хувилбараар судалж, нотлох баримтын хамт ирүүлэхийг зөвлөсний дагуу аймгийн ЗДТГ-ын СТСХ нь төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг дараах байдлаар нэмэгдүүлэн тооцсон байна. Үүнийг тодруулбал:

- *Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 796.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 946.9 сая төгрөгөөр,*
- *Орон нутгийн орлогын дансны үлдэгдэл буюу ахуйн нэгжийн орлогын албан татварын төлөвлөгөөнөөс давсан орлогыг 4,203.1 сая төгрөгөөр.*

2.1.6 Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2-т “Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашгаас дээд шатны төсөвт дараах байдлаар төвлөрүүлнэ: 56.2.1: доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас бага болон тэнцүү тохиолдолд үндсэн тэнцлийн ашгийн ... 70 хувийг 2020 оны төсвийн жилээс эхлэн тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ.” гэж заасан байдаг.

2.1.7 Тайлант онд Баянгол сумаас 141.5 сая төгрөг, Ерөө сумаас 987.2 сая төгрөг, Мандал сумаас 1,266.5 сая төгрөг, Сайхан сумаас 291.3 сая төгрөг, Сүхбаатар сумаас 2,297.6 сая төгрөг, Хүдэр сумаас 281.2 сая төгрөг нийт **6 сумаас 5,265.3** сая төгрөгийн орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон байна.

2.1.8 Аудитаар дээрх сумдын 2025 оны суурь орлого, зарлагыг тооцоолж, төсвийн үндсэн тэнцлийн ашгаас аймгийн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон орлогыг давтан тооцоолж хяналаа.

Хүснэгт 1. Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо

(сая төгрөгөөр)

Д/д	Сумын нэр	Үндсэн тэнцлийн ашиг	Аймгийн төсөвт төвлөрүүлбэл зохих дүн, (30 хувь)	Аймгийн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон дүн
1	Баянгол	471.60	141.5	141.5
2	Ерөө	3,290.80	987.2	987.2
3	Мандал	4,221.70	1,266.50	1,266.50
4	Сайхан	970.8	291.3	291.3
5	Сүхбаатар	7,658.70	2,297.60	2,297.60
6	Хүдэр	937.4	281.2	281.2
	дүн	17,551.00	5,265.30	5,265.30

Эх сурвалж: Аймгийн 2026 оны төсвийн төсөл

2.1.7 Дээрхээс үзэхэд 2026 онд сумдаас төвлөрүүлэх орлогыг хуульд заасны дагуу үнэн зөв тооцоолсон байна.

2.1.8 Төрийн аудитын байгууллагаас тайлан оны 7 дугаар сард “Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д гүйцэтгэлийн аудит хийж цагдаа, байгаль орчны улсын байцаагч гэх мэт эрх бүхий албан тушаалтны ногдуулсан торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэх замаар 685.1 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэх нөөц боломж байгаа талаар аймаг, сумдын Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлсэн. Тодруулбал:

- Аймгийн Цагдаагийн газар болон Мандал, Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтэс нь бэлэн бусаар ногдуулсан нийт 523.1 сая төгрөгийн,
- Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь нийт 162.0 сая төгрөг.

2.1.9 Тус зөвлөмжийг хэрэгжүүлснээр аймгийн хүү, торгуулийн орлогыг 162.0 сая төгрөгөөр, Сүхбаатар, Мандал, Сайхан сумын хүү, торгуулийн орлогыг 523.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, эдгээр сумдын үндсэн тэнцлийн ашгийн 30 хувь буюу аймагт төвлөрүүлэх орлогыг 156.9 сая төгрөгөөр нийт **318.9 сая** төгрөгөөр орлогыг нэмэгдүүлэх нөөц боломж байна.

2.2 ТАТВАРЫН ӨРИЙГ ХУУЛЬД ЗААСАН ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР БАРАГДУУЛЖ ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ НӨӨЦ БОЛОМЖИЙГ ТООЦСОН БАЙНА.

2.2.1 Монгол Улсын жил бүрийн Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад “Татвар хураалт орлого бүрдүүлэлтийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон үзүүлэлт”-ийн зорилтот түвшинг тооцохдоо өмнөх онуудын тайлангаар ногдуулсан татварын өр барагдуулалтыг 70 хувиар, төлөвлөж буй жилийн өмнөх жилийн татварын тайлангийн ногдол, өр барагдуулалтыг 80 хувиар тус тус тогтоож, төсвийн орлогыг төлөвлөхөөр заасан байдаг.

2.2.2 Аймаг, сумд 15 нэр төрлийн татвар, төлбөр хураамжийн орлогоос 2024 оны жилийн эцэст 16,733.5 сая төгрөгийн татварын өртэй байсан бол тайлант онд 41,717.9 сая төгрөгийн ногдол үүсэж, урьд оны өр төлбөрөөс 11,902.9 сая төгрөг, тайлант оны ногдуулалтаас 34,951.3 сая төгрөг нийт 46,854.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 2025 оны 11 сарын байдлаар 80.2 хувийн биелэлттэй буюу 11,597.3 сая төгрөгийн татварын өрийн үлдэгдэл байна.

2.2.2 Аймгийн Татварын газар болон ЗДТГ-ын СТСХ аймаг, сумдын 2026 оны төсвийн орлогыг төлөвлөхдөө татварын өрийг хуульд заасан хувь хэмжээгээр барагдуулж, орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг тооцож, үнэн зөв төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 3. СУМДЫН ЗДТГ-ЫН БҮТЭЦ ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АКТАД НИЙЦҮҮЛЭН ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

3.1 ОРОН НУТГИЙН НӨӨЦ БОЛОМЖИД ҮНДЭСЛЭН СУУРЬ ЗАРДЛЫГ 24,773.9 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

3.1.1 Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсөл боловсруулах журам”-ын 4.3.2-т заасны дагуу орон нутгийн төсөвт байгууллагуудын 2026 оны төсвийн төслийг хүлээн авч, Сангийн Яамнаас ирүүлсэн удирдамж чиглэлийн дагуу хянаж, төсвийн урсгал зардлыг төлөвлөсөн байна.

3.1.2 УИХ-аас Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн 2026 оны төсвийн суурь зарлагыг 66,372.9 сая төгрөгөөр (аймаг, сумдын) баталсан байна.

3.1.3 Үүнээс аймгийн төсвийн суурь зарлагыг 20,113.3 сая төгрөгөөр (урсгал зардал 15,771.6 сая төгрөг, хөрөнгө оруулалт 4,341.7 сая төгрөг), ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 24,972.6 сая төгрөгөөр зэрэг аймгийн нийт зарлагыг **45,085.9** сая төгрөгөөр баталсан байна.

3.1.4 Аймгийн Засаг дарга нь УИХ-аар баталсан аймгийн 2026 оны төсвийн урсгал зардлыг 24,773.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, **69,859.9** сая төгрөгөөр төлөвлөн аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна.

3.1.5 Засаг даргаас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд УИХ-аас батлагдаж ирсэн суурь урсгал зарлагыг 24,773.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд:

- Төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 2.3 дахь хэсэгт “ Орон нутагт ажилласны нэмэгдлийг тухайн орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны, үйлчилгээний

болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид нэмж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусган шийдвэрлэж болно.” гэж заасны дагуу цалин, НДШ-ийн зардлыг 1,474.7 сая төгрөгөөр,

- Засаг даргын ерөнхий дансыг 55.7 сая төгрөгөөр,
- Засаг даргын нөөц хөрөнгийг 550.9 сая төгрөгөөр,
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлыг 2,000.0 сая төгрөгөөр,
- Төрийн өмчит барилгын тогтмол зардлыг 1,304.3 сая төгрөгөөр,
- УИХ-аас батлагдсан орон тооны хязгаараас 3 орон тоог нэмэгдүүлэн цалин, НДШ-ийн зардлыг 129.8 сая төгрөгөөр,
- Улсын төсвийн байгууллагуудад олгох орон нутгийн нэмэгдлийг 2,218.7 сая төгрөгөөр,
- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 2,299.7 сая төгрөгөөр,
- Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 13,784.4 сая төгрөгөөр
- Бусад зардлыг 955.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.2 УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЖ, КОМИССЫН АКТААР ХҮЛЭЭН АВСАН ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ АШИГЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

3.2.1 Төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах үйл ажиллагааг Монгол улсын тухайн жилийн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль эрхийн актууд, төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжид нийцүүлэн үр ашиг, үр нөлөө, арвилан хэмнэлттэй байхаар төсөвлөж, төлөвлөхөөр зохицуулагдсан байдаг.

3.2.2 Гэтэл аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн 2026 оны орон нутгийн төсвийн төсөлд төсөл арга хэмжээг зардлын дэлгэрэнгүй тооцоо судалгаагүйгээр бөөн дүнгээр төсөвлөсөн, батлагдсан орон тооны хязгаарыг нэмэгдүүлсэн зэрэг өмнөх онд төсвийг үр ашиг, арвилан хэмнэлтгүйгээр төлөвлөсөн зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн **2,000.0** сая төгрөгийн зардлыг төсөл, арга хэмжээгээр салгаж, тооцоо судалгаа хийлгүйгээр бөөн дүнгээр төсөвлөсөн нь төсвийн хяналт сулрах, хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна,
2. Аймгийн Засаг даргын тамгын газрын зардлыг холбогдох нотлох баримт, тооцоо судалгааг ирүүлэхгүйгээр цалин, хөлс болон нэмэгдэл урамшлыг 716.9 сая төгрөгөөр, НДШ-ийг 89.6 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 653.3 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 35.0 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 45.0 сая төгрөгөөр буюу нийт **1,539.8** сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна,
3. Аймгийн төсвийн 3 байгууллагын орон тоог Сангийн Яамнаас 2026 онд 18 байхаар хянасныг 3-аар нэмэгдүүлж 21 болгон, нийт **129.8** сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал нэмэгдэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- СХДАА: Сангийн яамнаас 6 орон тоотойгоор хянасан боловч хязгаараас 1-ээр нэмэгдүүлж, 7 орон тоотойгоор,
- ОНӨГ: Сангийн яамнаас 6 орон тоотойгоор хянасан боловч хязгаараас 1-ээр нэмэгдүүлж, 7 орон тоотойгоор,

- ХААГ: Сангийн яамнаас 6 орон тоотойгоор хянасан боловч хязгаараас 1-ээр нэмэгдүүлж, 7 орон тоотойгоор гэх мэт.

3.2.3 Аудитаар сумдын суурь зарлагад төлөвлөсөн ЗДТГ-ын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоол, Сангийн яамнаас хянасан суурь зарлага, аймгийн Засаг даргын 2015 оны А/475 дугаар захирамжтай харьцуулан дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Сумдын ЗДТГ-ын орон тооны судалгаа

№	Сумдын нэр	Засгийн газрын 2018 оны 267-р тогтоол	Аймгийн Засаг даргын 2015 оны А/475-р захирамж	2026 оны төсвийн төсөл	Зөрүү
		А	Б	В	Г=В-А
1	Алтанбулаг	16	19	18	2
2	Баруунбүрэн	16	17	18	2
3	Баянгол	18	19	20	2
4	Ерөө	18	20	20	2
5	Жавхлант	15	16	17	2
6	Зүүнбүрэн	15	16	17	2
7	Мандал	23	24	25	2
8	Орхон	15	16	17	2
9	Орхонтуул	16	20	18	2
10	Сайхан	18	19	20	2
11	Сант	15	16	17	2
12	Сүхбаатар	23	24	25	2
13	Түшиг	15	16	17	2
14	Хушаат	15	16	17	2
15	Хүдэр	15	16	18	3
16	Цагааннуур	18	20	20	2
17	Шаамар	16	17	19	3
	НИЙТ	287	311	323	36

Эх сурвалж: Аймгийн 2026 оны төсвийн төсөл

3.2.4 Дээрхээс үзэхэд аймгийн Засаг даргын 2015 оны “Сумын Засаг даргын Тамгын газар, тосгоны Захирагчийн бүтэц орон, тоог шинэчлэн батлах тухай” А/475 дугаар захирамжаар батлагдсан бүтэц, орон тоог Засгийн газрын 2017 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 253, 2018 оны “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 267 дугаар тогтоолуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.2.5 Цаашид орон нутгийн төсвийн байгууллагуудад шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтаршуулах арга хэмжээ авч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана: 15.2.6 дахь байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэсэн заалт болон Сангийн яамнаас хянаж, УИХ-аар баталсан орон тооны хязгаарыг баримтлан төсвийн урсгал зардлыг бууруулах нь зүйтэй юм.

3.2.6 Төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалтын

судалгааг сумдаас авч үр дүнг тооцоход дараах байдалтай байна. Үүнийг тодруулбал:

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймагт үйлдвэрлэл хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийгдэж байнгын ашиглалтад хүлээн авсан 4,201.2 сая төгрөгийн дараах хөрөнгүүд нь дутуу буюу огт ашиглалтгүй байна.

Хүснэгт 3. Хөрөнгө ашиглалттай холбоотой судалгаа

(сая төгрөгөөр)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Эх үүсвэр	Ашиглалтад хүлээн авсан он	Төсөвт өртөг
1	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Сэлэнгэ, Баянгол сум/	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	2024	2,000.0
2	Бохирын байгууламж /Хүдэр сум/	Орон нутгийн хөрөнгө оруулалт	2017	321.3
3	Бордооны цех байгуулах /Баруунбүрэн сум/	Орон нутгийн хөрөнгө оруулалт	2023	175.0
4	Ерөө суманд 35 ширхэг хүлэмж	Улсын төсвийн хөрөнгө оруулалт - ХХААХҮЯ	2022	192.8
5	Цагааннуур суманд 35 ширхэг хүлэмж	Улсын төсвийн хөрөнгө оруулалт - ХХААХҮЯ	2022	192.8
6	Орхон суманд 42 ширхэг хүлэмж	Улсын төсвийн хөрөнгө оруулалт - ХХААХҮЯ	2022-2024	192.8
7	Алтанбулаг суманд 35 ширхэг	Улсын төсвийн хөрөнгө оруулалт - ХХААХҮЯ	2022	192.8
8	Зүүнбүрэн суманд 75 ширхэг хүлэмж	Улсын төсвийн хөрөнгө оруулалт - ХХААХҮЯ	2022-2023	528.1
9	Шаамар суманд 30 ширхэг хүлэмж	Улсын төсвийн хөрөнгө оруулалт - ХХААХҮЯ	2022	405.6
Нийт				4,201.2

Эх сурвалж: Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын судалгаа

3.2.7 Иймд дээрх хөрөнгүүдийг иргэд, аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр ашиглуулах, түрээслэх эсвэл сонгон шалгаруулалт, дуудлага худалдаа зохион байгуулах замаар худалдах зэргээр хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж, ашиглалтыг нэмэгдүүлэх боломж байна.

БҮЛЭГ 4. АЙМГИЙН ОНХО, ОНХС, ЗАМЫН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР ЗУРАГ, ТӨСВИЙГ УРЬДЧИЛАН ХИЙЛГЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨСӨВЛӨСӨН БАЙНА.

4.1 ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ОНХО-ЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАСАН БАЙНА.

4.1.1 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2026 оны жагсаалтаар өмнөх оноос шилжин хэрэгжих 1,438.0 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 16 төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжих нийт 3,134.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 30 төсөл, арга хэмжээ, зэрэг нийт 6,840.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4,572.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 46 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр тусгагдсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. Аймгийн ОНХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа

(сая төгрөгөөр)

Ангилал	Өмнөх оноос шилжиж ирсэн			Шинээр эхлэх			Нийт		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж				2	545.4	545.4	2	545.4	545.4
Их засвар	10	2,976.0	1,037.8	6	1,479.6	1,235.0	16	4,455.6	2,272.8
Тоног төхөөрөмж	3	424.8	339.6	21	1,309.1	1,309.1	24	1,733.9	1,648.7
Зураг төсөв	3	60.6	60.6	1	45.0	45.0	4	105.6	105.6
Нийт	16	3,461.4	1,438.0	30	3,379.1	3,134.5	46	6,840.5	4,572.5

Эх сурвалж: Аймгийн 2026 оны төсвийн төсөл

4.1.2 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засварын төсөл, арга хэмжээний жагсаалтад шинээр хэрэгжүүлэх 633.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 8 төсөл, арга хэмжээг зураг төсөв, үнийн тооцоо судалгаагүйгээр төсөвлөсөн байна.

4.1.3 Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.”; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно: 13.3.3: “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.” гэж заасныг тус тус зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. Зураг төсөв, тооцоо судалгаагүй төлөвлөсөн төсөл, арга хэмжээний судалгаа

(сая төгрөгөөр)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Зураг төсөвгүй	Тооцоо судалгаагүй
1	Сургуулийн тоног төхөөрөмж худалдан авах /Шаамар сум, Дулаанхаан тосгон/		25.0
2	Цэцэрлэгийн тоног төхөөрөмж худалдан авах /Шаамар сум, Дулаанхаан тосгон/		20.0
3	Соёлын төвд хөгжим, техникийн хэрэгсэл худалдан авах /Шаамар сум, Дулаанхаан тосгон/		20.0
4	Сургуулийн хичээлийн танхимд сандал, ширээ худалдан авах /Мандал сум, Түнхэл тосгон/		30.0
5	Хогны машин худалдан авах /Сайхан сум/		120.0
6	Цагдаагийн байгууллагад автомашин худалдан авах		150.0
7	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасагт дурангийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн шинэчлэл		68.4
8	Спорт заалны засвар /Баруунбүрэн сум/	200.0	
	Дүн	200.0	433.4

Эх сурвалж: Аймгийн 2026 оны төсвийн төсөл

4.1.4 Улсын төсвийн байгууллагуудад тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл худалдан авах, байшин барилгыг засварлах зэрэг 3 төсөл, арга хэмжээнд нийт 442.9 сая төгрөгийг төсөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн

шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.” гэж заасныг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6. Улсын төсвийн байгууллагуудыг санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт

(сая төгрөгөөр)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	2026 онд санхүүжих дүн
1	Аймгийн онцгой байдлын газрын гражийн өргөтгөлийн барилга барих	265.4
2	Онцгой байдлын газарт дрон худалдан авах	27.5
3	Цагдаагийн байгууллагад автомашин худалдан авах	150.0
	Дүн	442.9

Эх сурвалж: Аймгийн 2026 оны төсвийн төсөл

4.1.5 Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан нийт 30 төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргын 2025–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан төлөвлөсөн байна.

4.1.6 Тайлант онд Замын сангийн хөрөнгөөр нийт 1,745.2 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжихээс 975.2 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг зураг төсөвгүйгээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 7. Зураг төсөв, тооцоо судалгаагүйгээр Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний судалгаа

(сая төгрөгөөр)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Зураг төсөвгүй
1	Төв замын шинэчлэлийн ажил /Ерөө сум, Бугант тосгон/	200.0
2	Сум доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл /Зүүнбүрэн сум/	200.0
3	Сумын төвийн зам шинэчлэлтийн ажил /Мандал сум, 7-р баг/	400.0
4	Зам давааны засвар /Сант сум/	175.2
	Дүн	975.2

Эх сурвалж: Аймгийн 2026 оны төсвийн төсөл

4.2 ЗУРАГ ТӨСВИЙГ УРЬДЧИЛАН ХИЙЛГЭЭГҮЙ БОЛОН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ОНХС-ИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

4.2.1 2026 онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжин хэрэгжих 6,703.5 сая төгрөгийн өртөг бүхий 12, шинээр хэрэгжих 7,509.8 сая төгрөгийн өртөг бүхий 30 зэрэг нийт 14,213.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8. ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа

(сая төгрөгөөр)

Ангилал	Өмнөх оноос шилжих			Шинэ			Нийт		
	Тоо	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
Барилга байгууламж	8	5,015.1	896.3	17	3,812.4	3,494.0	25	8,827.5	4,390.3
Тоног төхөөрөмж	1	610.0	104.0	1	150.0	150.0	2	760.0	254.0
Их засвар	1	678.4	278.4	10	2,997.4	2,677.4	11	3,675.8	2,955.8

Бусад ТЭЗҮ	2	400.0	155.7	1	150.0	150.0	3	550.0	305.7
Баяр наадам	-	-	-	1	400.0	400.0	1	400.0	400.0
Нийт	12	6,703.5	1,434.4	30	7,509.8	6,871.4	42	14,213.3	8,305.8

Эх сурвалж: Аймгийн 2026 оны төсвийн төсөл

4.2.2 Аймгийн Засаг даргын 2025 оны А/302 дугаар захирамжаар аймгийн төсвийн болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг байгуулсан боловч төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалт гаргаж, иргэд, олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй, санал авч, эрэмбэлэх ажил бүрэн хийгдээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.1.1⁴, 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.4⁵, 7.5⁶ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.2.3 2026 онд ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй 49.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дараах 1 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнд:

- 49.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сүхбаатар сумын 3-р сургуулийн E блокын дээвэр засвар”.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.2.4 Зураг төсөв, үнийн тооцоо судалгааг урьдчилан хийлгээгүй 10 төсөл, арга хэмжээнд нийт 3,037.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.4⁷, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.3⁸ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-т харуулав)

4.2.5 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2.1-4.2.8-д заасан ОНХС-ийн чиг үүрэгт үл хамаарах буюу хувийн эзэмшлийн орон сууцны барилгын гадна фасад засварын ажлын дараах 2 төсөл, арга хэмжээнд нийт **740.0** сая төгрөгийг төлөвлөсөн байна. Үүнд:

- 400.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “40-р байрны гадна фасад засвар (Мандал сум),
- 340.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “12 айлын 2 орон сууцны гадна фасад засвар (Мандал сум, 6-р баг).

⁴ Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж, жил бүрийн 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн саналыг авна.

⁵ Аймаг, нийслэлийн Засаг дарга ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна.

⁶ Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна.

⁷ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁸ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх.

4.2.6 Иргэд, олон нийтийг тав тухтай амьдруулах зорилгын хүрээнд нийтийн эзэмшлийн барилга байгууламжийг засаж сайжруулах, төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг хангаж, орон сууцаар хангах нь зүйтэй хэдий ч уг чиг үүргийг ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр бус тусгай хөтөлбөр боловсруулж, төсөл, хөтөлбөрийн төсөвт тусган, шийдвэрлэх нь оновчтой юм.

4.2.7 Хэдийгээр зураг төсөв нь хийгдсэн ч түүний **ҮНЭН ЗӨВИЙГ** магадлалаар баталгаажуулаагүй барилга, байгууламжуудыг аймгийн ОНХО, ОНХС болон Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь “... улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв”, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 6.3 дахь “*Барилгын тухай хуулийн 25.2, 25.3, 25.5-д заасан зураг төсөлд заавал магадлал хийнэ*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймгийн 2026 оны төсвийн төслийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй нийцүүлэн боловсруулсан байна.
- Аймгийн 2026 оны төсвийн төслийг хуульд заасан хугацаанд иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.
- Эрх бүхий албан тушаалтны ногдуулсан торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэх замаар 318.9 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэх нөөц боломж байна.
- Татварын өрийг хуульд заасан хувь хэмжээгээр барагдуулж орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг тооцсон байна.
- Орон нутгийн нөөц боломжид үндэслэн суурь зардлыг 24,773.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж, комиссын актаар хүлээн авсан зарим төсөл арга хэмжээний ашиглалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
- Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг ОНХО-ын төлөвлөгөөнд тусгасан байна.
- Зураг төсвийг урьдчилан хийлгээгүй болон чиг үүрэгт хамаарахгүй төсөл арга хэмжээг ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Г.Бат-Орхон -д:

- Төсвийн тухай хуулийн 29, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасныг үндэслэн зураг, төсвийг урьдчилан хийлгэсэн төсөл, арга хэмжээг ОНХО, ОНХС, Замын сангийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр батлах.
- Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт шалгалт зохион байгуулах.

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж-д:

- Төсвийн зарлагыг хэрэгжүүлэхэд шаардагдах орц, төсөв, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх үр дүнг хөтөлбөрөөр болон эдийн засгийн ангиллаар илэрхийлсэн зарлагын хуваарилалтын тооцоонд үндэслэн төлөвлөж, батлуулах.
- Орон нутгийн байгууллагуудын бүтэц, орон тооны хязгаарыг холбогдох хууль, эрх зүйн актад нийцүүлэн шинэчилж, чиг үүргийн шинжилгээ хийн, давхардлыг арилгах замаар төсвийн зарлагыг бууруулах.
- Зураг, төсвийг урьдчилан хийлгэсэн төсөл, арга хэмжээг ОНХО, ОНХС, Замын сангийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, батлуулах.
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж, комиссын актаар хүлээн авсан төсөл арга хэмжээний ашиглалтад тавих хяналтыг сайжруулах замаар төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Б.БАТМӨНХ

Ц.ОТГОНБАЯР

С.БААСАНСҮРЭН

О.АНХБАЯР

Ж.ЦОГТ



Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэхээр зураг, төсөвгүйгээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг /мян.төг/	2026 онд санхүүжүүлэх дүн /мян.төг/	Зураг, төсвийг	
		Эхлэх	Дуусах			ТАХ-ний тоо	Төсөвт өртөг /мян.төг/
ЗАСАГ ДАРГА				14,213,227.2	8,305,849.5		
1	Хөрөнгө оруулалт			8,813,447.0	4,376,277.5		
1.1	Шилжих хөрөнгө оруулалт			5,015,076.6	896,277.5		
1.1.1	Үерийн далан /Баянгол сум/	2023	2026	1,751,800.0	-		
1.1.2	Өндрийн усан сан /Орхон сум/	2023	2026	694,926.4	89,926.4		
1.1.3	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт /Мандал сум, Хэрх тосгон/	2023	2026	397,012.0	-		
1.1.4	Инженерийн шугам сүлжээний шинэчлэл /Алтанбулаг сум/	2025	2026	500,000.0	50,000.0		
1.1.5	Төрийн албан хаагчдын байр барих /Баруунбүрэн сум/	2025	2026	450,000.0	214,183.4		
1.1.6	Бохирын шугам /Сүхбаатар сум, 4-баг/	2025	2026	300,000.0	300,000.0		
1.1.7	Гудамж талбайн гэрэлтүүлэг /Хушаат сум/	2025	2026	595,000.0	206,433.1		
1.1.8	Төрийн албан хаагчийн байрыг дулаанд холбох /Шаамар, Дулаанхаан тосгон/	2025	2026	326,338.2	35,734.6		
1.2	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт			3,798,370.4	3,480,000.0	6	1,250,000.0
1.2.1	Цэвэршүүлсэн ус түгээх төв шинээр байгуулах /Алтанбулаг сум/	2026	2026	127,951.0	127,951.0		
1.2.2	Дулаан, цэвэр усны шугам шинээр тавих /Алтанбулаг сум/	2026	2026	212,049.0	212,049.0		
1.2.3	Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт /Орхонтүүл сум, Рашаант тосгон/	2026	2026	150,000.0	150,000.0	1	150,000.0
1.2.4	Наадмын талбай шинээр байгуулах /Орхонтүүл сум/	2026	2027	300,000.0	150,000.0	1	300,000.0
1.2.5	Дулааны шугам шинэчлэл /Түшиг сум/	2026	2026	200,000.0	200,000.0		
1.2.6	Гэрэлтүүлгийн ажил /Хүдэр сум/	2026	2026	200,000.0	200,000.0	1	200,000.0
1.2.7	Камержуулалтын ажил /Баянгол сум/	2026	2026	185,000.0	185,000.0		
1.2.8	Бохирын шугамын ажил /Сүхбаатар сум, 4-р баг/	2026	2026	200,000.0	200,000.0		
1.2.9	Инженерийн шугам сүлжээний ажил /Сүхбаатар сум 8-р баг/	2026	2026	170,000.0	170,000.0		
1.2.10	Гэрэлтүүлгийн ажил /Сүхбаатар сум, 1-р баг/	2026	2026	400,000.0	400,000.0		
1.2.11	Бохирын шугамын ажил /Сүхбаатар сум, 3-р баг/	2026	2026	200,000.0	200,000.0		
1.2.12	Бага сургуулийн гадна цахилгааны ажил /Мандал сумын, Тарни баг/	2026	2026	405,000.0	405,000.0		
1.2.13	Гудамж талбайн гэрэлтүүлгийн ажил /Шаамар сум, Дулаанхаан тосгон/	2026	2026	80,000.0	80,000.0		
1.2.14	Төмөр замын 3-р 60 айлд 5x5 сагсан бөмбөгийн талбайтай гадна талбайн тохижилт /Сүхбаатар 7-р баг/	2026	2027	368,370.4	200,000.0		
1.2.15	Гадна талбайн тохижилт ажил /Сүхбаатар сум, Бор гүвээ, 5-р баг/	2026	2026	200,000.0	200,000.0	1	200,000.0
1.2.16	Төрийн албан хаагчийн орон сууц худалдан авах /Орхон сум/	2026	2026	200,000.0	200,000.0	1	200,000.0
1.2.17	Дотор зам засвар, шинэчлэлтийн ажил /Сүхбаатар сум, 6-р баг/	2026	2026	200,000.0	200,000.0	1	200,000.0
2.1	Тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил			760,000.0	254,056.1		
2.1.1	Шилжих хөрөнгө оруулалт			610,000.0	104,056.1		
2.1.1.1	Автозам арчилгааны техник худалдан авах /Цагааннуур сум/	2025	2026	610,000.0	104,056.1		
2.1.2	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт			150,000.0	150,000.0	-	-
2.2.1	Эрүүл мэндийн төвд бүрэн тоноглогдсон автомашин нийлүүлэх /Ерөө сум/	2026	2026	150,000.0	150,000.0		
3.1	Их засвар			3,689,780.2	2,969,780.2		
3.1.1	Шилжих хөрөнгө оруулалт			678,366.0	278,366.0		
3.1.1.1	Төрийн албан хаагчийн байрны засвар /Мандал, Хэрх тосгон/	2025	2026	678,366.0	278,366.0		
3.2.1	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт			3,011,414.2	2,691,414.2	4	1,787,289.4

3.2.1.1	Төрийн албан хаагчдын орон сууц засварлах /Жавхлант сум/	2026	2027	470,000.0	150,000.0		
3.2.1.2	12 айлын 2 орон сууцны гадна фасад засвар /Мандал сум, 6-р баг/	2026	2026	340,000.0	340,000.0	1	340,000.0
3.2.1.3	Сумын газар зүйн нэрийн зураг тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх /Цагааннуур сум/	2026	2026	19,600.0	19,600.0		
3.2.1.4	40-р байрны гадна фасадны засвар /Мандал сум/	2026	2026	400,000.0	400,000.0	1	400,000.0
3.2.1.5	Нэгдсэн үйлчилгээний төвийн их засвар /Цагааннуур сум/	2026	2026	373,200.0	373,200.0		
3.2.1.6	1-р цэцэрлэгийн гадна фасад засвар /Мандал сум/	2026	2026	423,456.4	423,456.4	1	423,456.4
3.2.1.7	Эрүүл мэндийн төвийн дотор сантехникийн их засвар /Сайхан сум/	2026	2026	623,833.0	623,833.0	1	623,833.0
3.2.1.8	Сургуулийн дотуур байрны цахилгааны иж бүрэн засвар /Мандал сум/	2026	2026	54,881.2	54,881.2		
3.2.1.9	Сүхбаатар сумын 3-р сургуулийн Е блокын дээвэр засвар	2026	2026	49,225.6	49,225.6		
3.2.1.10	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх болон эмэгтэйчүүдийн тасгийн засвар	2026	2026	257,218.0	257,218.0		
4.1	Бусад ТЭЗҮ			550,000.0	305,735.7		
4.1.1	Шилжих хөрөнгө оруулалт			400,000.0	155,735.7		
4.1.1.1	Инженерийн шугам сүлжээний зураг төсөв /Баянгол сум/	2025	2026	100,000.0	25,735.7		
4.1.1.2	Инженерийн шугам сүлжээний зураг төсөв /Ерөө сум/	2025	2026	300,000.0	130,000.0		
4.2.1	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт			150,000.0	150,000.0		
4.2.1.1	Зураг төсвийн зардал /Мандал сум, Түнкэл тосгон/	2026	2026	150,000.0	150,000.0		
5.1	Бусад			400,000.0	400,000.0	-	-
5.1.1	Баяр наадмын зардал	2026	2026	400,000.0	400,000.0		
	Нийт			14,213,227.2	8,305,849.5	10	3,037,289.4